# Авлига, ашиг сонирхлын зөрчил




Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

## *Хууль эрх зүйн орчин*

**2005 он – НҮБ-ын Авлигын эсрэг конвенци**

**2006 он – Авлигын эсрэг хууль**

**2012 он - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль**

# Авлигын гэмт хэрэг

- Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах;
- Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх;
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах;
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх;
- Хээл хахууль авах;
- Хээл хахууль өгөх;
- Хээл хахууль зуучлах;
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Хууль бусаар хөрөнгөжих.

# Авлигын зөрчил



Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;



Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;



Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хүнд, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;



Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;



Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;



Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;



Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;



Үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



**Албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



**Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



**Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



**Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



**Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ




**Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ




**Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;**

# АВЛИГЫН ЗӨРЧИЛ



## Үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

***Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.***



# Авлига≠Ашиг сонирхлын зөрчил

н

оо

х

Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш, харин авлига бий болох хөрс суурь, шалтгаан болдог.

**Авлига бол ашиг сонирхлын зөрчлийн төгсгөлийн шат юм.**

Албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ субьектив, танил тал харсан, алагчилсан байдлаар гүйцэтгэхэд хүргэдэг, нийтийн албаны ёс зүйн болон захиргааны зөрчилд тооцогдох олон төрлийн зан үйлийн хэлбэрүүдийг өөртөө багтаадаг.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь **авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх томоохон механизмд тооцогддог.**

# АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль*

**Ашиг сонирхын зөрчил**

- Урьдчилан сэргийлэх
- Хориглолт, хязгаарлалт
- Шийдвэрлэх
- Хариуцлага тооцох

# Энгийн үгээр

- Төрийн ажил албан тушаалыг ашиглан баяжих, хөрөнгөжих хэрэгсэл болгож болохгүй.
- Төрийн ажил албан тушаалыг төрөл садангийн алба болгон хувиргаж болохгүй.
- Төрийн ажил албан тушаалыг хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх хэрэгсэл болгон харж болохгүй.

Төрийн алба хаагч та:

- Өөртэйгээ
- Хамаарал бүхий этгээдтэйгээ /гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, өөрийн болон эхнэр, нөхрийн хөө эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү/
- Нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ /ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд/ холбоотой захиргааны ямар нэг шийдвэр гаргахыг хориглосон

## Ашиг сонирхлын зөрчил

Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ.




# Хувийн ашиг сонирхол

Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхол



## Нийтийн ашиг сонирхол

**Нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг хэлнэ.**

Ашиг сонирхлын зөрчил нь авлига биш, харин а
бий болох хөрс суурь, шалтгаан болдог.

**Авлига бол ашиг сонирхлын зөрчли**
**төгсгөлийн шат юм.**

Албан тушаалаа зүй бусаар ашиглан хувьдаа
санхүүгийн ашиг олохгүй ч албан үүргээ субъек
танил тал харсан, алагчилсан байдлаар гүйцэт
хүргэдэг, нийтийн албаны ёс зүйн болон захирга
зөрчилд тооцогдох олон төрлийн зан үйлийн
хэлбэрүүдийг өөртөө багтаадаг.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь **авлиг**
**урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх том**
**механизмд тооцогддог.**

# АСЗ-ийн төрлүүд

## Ойлгогдохуйц

Энэ нь мэдээлэлтэй иргэд ашиг сонирхлын зөрчил үүссэн байна гэж үнэмшихүйц нөхцөл байдал бий болсныг ойлгоно.
"ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" Хуулийн 3.1.11

тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.

## Бодит

Энэ нь албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхол нь хангалттай хэмжээнд зүй бусаар нөлөөлж буй нөхцөл байдал.

***Жишээ нь: Үнэлгээний хорооны даргаар ажиллаж буй Нийтийн албан тушаалтан өөрийн төрсөн дүүгийн компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж гэрээ байгуулах.***

## Болзошгүй

Энэ нь одоогоор ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсээгүй ч ирээдүйд бодит зөрчилд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг ойлгоно.

*Жишээ нь: Нийтийн албан тушаалтан Б ажил үүргийнхээ дагуу А компанитай холбогдох шийдвэр гаргах болсон ба тухайн албан тушаалтны гэр бүлийн хүн уг компанийн захирлаар 7 хоногийн дараа томилогдох нь тодорхой болсон. Энэ тохиолдолд одоогоор ашиг сонирхлын зөрчил үүсээгүй боловч ирээдүйд бодит ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй.*

# Бодит

Энэ нь албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхол нь хангалттай хэмжээнд зүй бусаар нөлөөлж буй нөхцөл байдал.

***Жишээ нь: Үнэлгээний хорооны даргаар ажиллаж буй Нийтийн албан тушаалтан өөрийн төрсөн дүүгийн компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж гэрээ байгуулах.***

# Ойлгогдохуйц

Энэ нь мэдээлэлтэй иргэд ашиг сонирхлын зөрчил үүссэн байна гэж үнэмшихүйц нөхцөл байдал бий болсныг ойлгоно.
"ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" Хуулийн 3.1.11

тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.

агаа

# Болзошгүй

Энэ нь одоогоор ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүсээгүй ч ирээдүйд бодит зөрчилд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг ойлгоно.

*Жишээ нь: Нийтийн албан тушаалтан Б ажил үүргийнхээ дагуу А компанитай холбогдох шийдвэр гаргах болсон ба тухайн албан тушаалтны гэр бүлийн хүн уг компанийн захирлаар 7 хоногийн дараа томилогдох нь тодорхой болсон. Энэ тохиолдолд одоогоор ашиг сонирхлын зөрчил үүсээгүй боловч ирээдүйд бодит ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй.*

# Төрийн байгууллагын удирдлагын хүлээх үүрэг

- Ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх
- Мэдүүлэг, мэдэгдлийг авах, бүртгэх, хянан шалгах;
- Зөрчлийн талаар мэдээлэл хүлээх авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;
- АСЗ үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, түүнд АСЗ-өөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар Зөвлөмж өгөх;
- Давхар ажлын талаар шийдвэр гаргах.




# Ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх

- Ашиг сонирхлоо зарлах;
- Хувийн сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргахад албан тушаалтан оролцохоос татгалзах;
- Албан үүргийг зөрчил үүсэхгүй чиг үүрэгт шилжүүлэх;
- Албан хаагчийн ажил үүргийг дахин өөрчлөх тодорхойлох;
- Зөрчил үүсгэх чиг үүргээс чөлөөлөх гэх мэт байдлаар шийдвэрлэнэ.

  23-27-р зүйл /

/




# Хариуцлага тооцох

- Сануулах;
- Цалинг тодорхой хэмжээгээр бууруулах;
- Мөнгөн торгууль ногдуулах;
- Хууль бус үйл ажиллагааг нь хүчингүй болгох;
- Албан тушаалаас бууруулах;
- Нийтийн албанаас халах.

# Анхаарал хандуулсанд баярлалаа